

2016 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

1. Төслийн ерөнхий мэдээлэл:

а) Төслийн нэр:

“Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг бэхжүүлэх”-2 төсөл

б) Зорилтот бүлэг

1. Зорилтот аймгуудын эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнууд
 - а. Эрүүл мэндийн газрын удирдлага, мэргэжилтэн
 - б. Засаг даргын тамгын газрын нийгмийн хөгжлийн хэлтсийн эрүүл мэнд хариуцсан түшмэл
2. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд:
 - а. Их эмч
 - б. Эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд; багийн бага эмч, сувилагч, эх баригч, эмийн санч
 - с. Нийгмийн эрүүл мэндийн ажилтнууд
3. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, мэдлэгийг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэж буй бусад салбарын мэргэжилтнүүд
 - а. Сургуулийн эмч, эрүүл мэндийн багш нар
 - б. Цэцэрлэгийн багш нар
4. Зорилтот бүлгийн олон нийт
 - а. 1-9 дүгээр ангийн ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүд
 - б. Цэцэрлэгийн хүүхдүүд

2. 2016 оны төлөвлөгөөний дагуу төслийн хэрэгжилт:

-2016 онд төлөвлөсөн үйл ажиллагаа 1-р зорилт 91%, 2-р зорилт 100%, 3-р зорилтын хүрээнд 89%-ийн биелэлттэй байна. БӨ аймагт Боловсрол соёл урлагийн газрын идэвх санаачилга сулаас шалтгаалан эрүүл мэндийн олимпиад, эрүүл мэндийн кабинет шалгаруулах үйл ажиллагаа, Ховд аймагт ТББ-ын уулзалт, хяналт үнэлгээний ажлын хэсгийн 3 дах уулзалт, ГА аймагт өсвөр үеийн сурагчдын төсөлд дэмжлэг үзүүлэх, хяналт үнэлгээний ажлын хэсгийн 3 дахь уулзалт зэрэг 6 үйл ажиллагаа хийгдээгүй байна. Нийт 18 ажил орон нутгийн сонгууль, сургагч багш нар болон орон нутгийн хамтрагчдын ажлын давхардал, ачаалал зэргээс шалтгаалан хугацаа хойшлогдож хэрэгжсэн.

- Орон нутгийн хүсэлт, хэрэгцээг үндэслэн Төслийн баримт бичигт тусгагдаагүй дараах үйл ажиллагааг 2016 оны төлөвлөгөөнд оруулан зохион байгуулсан. Үүнд:

1. Аймгийн ЭМГ-ын мэргэжилтнүүдэд “Чанар сайжруулах арга зүй”, “Судалгаа хийх арга зүй” сэдэвт сургалт
2. СӨЭМТ-ийн эмч нарт зориулсан шавилан, ХӨЦМ-ийн сургалт
3. Өсвөр үеийн эрүүл мэнд бүсийн зөвлөлдөх уулзалт

-ГА аймагт жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй 2 үйл ажиллагааг орон нутгийн хэрэгцээг үндэслэн төслийн удирдлагууд зөвшилцсөний дагуу АЭМГ-тай хамтран зохион байгуулсан.

Эерэг өөрчлөлт:

- ЭМГ, БСГ- уудын мэргэжилтнүүдийн хамтарсан хяналт үнэлгээний өргөтгөсөн хурлаас гарсан саналын дагуу Ховд аймгийн Ховд суманд зөвхөн “ Хүүхэд өсвөр үеийн эрүүл мэндийг үнэлэх нь” сэдэвтэй удирдамж гарган 2 байгууллага ЭМТ, сургууль

цэцэрлэгийн үйл ажиллагаанд үнэлгээ хийсэн нь харилцан бие биенээсээ суралцаж нэгдсэн үнэлгээ хийхэд ихээхэн ач холбогдолтой үйл ажиллагаа болов. Мөн эдгээр байгууллагууд жилийн турш хамтран хэрэгжүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Сөрөг өөрчлөлт:

- Мөн оны 4-р улиралд хүүхдийн дунд амьсгалын замын цочмог халдвар эрс нэмэгдсэн ялангуяа Ховд аймагт нөхөн үржихүйн насны хүмүүсийн дунд бэлгийн замын халдвар ихэссэн зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан эрүүл мэндийн зарим үндсэн үзүүлэлтүүдэд сөрөг үр дүн гарлаа.

- Орон нутгийн ТББ-дын чадавхи сул, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах туршлага сонирхол муу байдгаас тэдэнтэй хамтарсан үйл ажиллагаанд ахиц гарсангүй.

3. Жилийн туршид хүрсэн үр

Хөгжлийн шалгуур үзүүлэлт:

1. *Сум өрхийн ЭМТ/сум дундын эмнэлгээр/ -өөр үйлчлүүлэх хүмүүсийн тоо нэмэгдэнэ.* 2016 онд сум өрхийн ЭМТ-өөр үйлчлүүлсэн хүмүүсийн тоо ГА аймагт 70452 болж 2015 оноос 6258-аар нэмэгдсэн байна.

2. *5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл буурна.* 2016 онд БӨ аймаг 32.1, ГА аймаг 20.4, Ховд аймаг 23.4 промил болж өмнөх оноосоо 0.1-4.9 пормилээр нэмэгдсэн ба БӨ, Ховд аймгууд улсын дунджаас¹ дээгүүр байна. Хүүхдийн эндэгдэл улсын хэмжээнд өмнөх оныхоос 2,5 промиллээр өссөн. Үүнд оны эхэнд улаан бурхан өвчний дэгдэлт ихэссэн, 1 болон 4-р улиралд гарсан амьсгалын замын цочмог халдварт өвчин², жирэмсний хяналт, нярайн тусламжийн чанар хүртээмж сул зэрэг хүчин зүйлүүд сөрөгөөр нөлөөлөв. Зорилтот аймгуудын хүүхдийн эндэгдэлд сөрөг нөлөө үзүүлж буй шатгаан хүчин зүйлийн талаар хэлэлцэж төслөөс зарим тоног төхөөрөмж болон сургалтын дэмжлэг төслөөс үзүүлэн ажиллахаар болсон.

Зорилтын шалгуур үзүүлэлт:

1а: Анхан шатанд ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулахад зориулсан санхүүжилт нэмэгдсэн байна.

-СӨЭМТ-үүдэд /Анхан шатанд/ ажиллаж байгаа эмч мэргэжилтнүүдэд багц цагийн сургалт³ыг АЭМГ ууд бие даан өөрийн санхүүжилтээр тасралтгүй зохион байгуулдаг болсоноор сургалтад зориулсан санхүүжилтийн хэмжээ жил бүр нэмэгдэж байна.

1б: АЭМГ орон нутагт тохирсон хяналт үнэлгээний аргачлалыг боловсронгуй болгож, тогтмол ашигладаг болсон байна.

- Төсөл хэрэгжих явцад хяналт үнэлгээний удирдамж, зарчим, шалгах хуудсыг төслийн баг болон АЭМГ хамтарч шинээр боловсруулан жил бүр шинэчлэн сайжруулан ашиглаж хэвшээд байна. Тухайлбал 2016 онд Чанар сайжруулах сургалтын явцад АЭМГ-ын мэргэжилтнүүд чанарын үнэлгээний шалгах хуудсыг 6 чиглэлээр шинэчлэн боловсруулан ашиглаж байна.

1с: АЭМГ-ын дэмжлэгт үйл ажиллагаанд анхан шатанд ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн сэтгэл ханамжийн түвшин дээшилсэн байна.

1 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл улсын дундаж 20,8 промилл.

2 Амьсгалын замын халдварт өвчин өмнөх оноос 8598 тохиолдлоор нэмэгдсэн.

3 Жил тутам их эмч нар 6, эмнэлгийн бусад мэргэжилтэн 4 багц цагийн сургалтанд хамрагдаж эмчлэх сувилах эрхээ сунгуулдаг журамтай.

- АЭМГ-ын дэмжлэгт үйл ажиллагаанд СӨЭМТ-үүдийн эмч, мэргэжилтнүүдийн сэтгэл ханамж 2015 онд аймгуудын дундаж 78% байсан бол 2016 онд 80% болж 2 хувиар дээшилсэн байна⁴.

2a: Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин дээшилсэн байна.

Үзүүлэлт	Баян-Өлгий		Говь-Алтай		Ховд	
	2015	2016	2015	2016	2015	2016
Сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан хүний тоо	3750	9140	748	1425	2200	2850
Эерэг үнэлгээ өгсөн үйлчлүүлэгчдийн эзлэх хувь	85.9	82.2	84.5	85.0	82.0	88.0

2b: Сум, өрхийн эмч нараар анх оношлогдсон хүний тоо нэмэгдсэн байна.

Үзүүлэлт	Баян-Өлгий		Говь-Алтай		Ховд	
	2015	2016	2015	2016	2015	2016
СӨЭМТ-өөр анх оношлогдсон хүний тоо	4480		7026		3968	5167

3a: Антибиотикийн хэрэглээ буурна. (тарилгаар)

Үзүүлэлт	Баян-Өлгий		Говь-Алтай		Ховд	
	2015	2016	2015	2016	2015	2016
Нийт хэвтсэн хүнээс антибиотик хэрэглэсэн хүний эзлэх хувь	92.0	94.0	87.0	85.0	86.0	83.0
Үүнээс тарилгаар хэрэглэсэн хүний эзлэх хувь	86.0	89.0	96.0	94.0	84.0	81.0

3b: Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд шүдээ тогтмол угаадаг дадал бүхий хүүхдийн эзлэх хувь нэмэгдэнэ.

Үзүүлэлт	Баян-Өлгий		Говь-Алтай		Ховд	
	2015	2016	2015	2016	2015	2016
Амны хөндийн эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо	5500	6500	12443	12884	15522	15916
Шүд цооролтой хүүхдийн эзлэх хувь /тархалт/	78.3	77.8	46.5	49,9	70.0	37.5
Шүдээ зөв угаах дадал эзэмшсэн хүүдийн эзлэх хувь /7-11 насны хүүхэд/ ⁵ -2016 оны байдлаар	Суурь судалгаа хийгдээгүй	Судалгааны дүн гараагүй	Суурь судалгаа хийгдээгүй	49.8	Суурь судалгаа хийгдээгүй	52,6
Шүдний эрүүл мэндийн талаарх хангалттай мэдлэгтэй хүүхдийн эзлэх хувь /12-15 насны хүүхэд/ ⁶ - 2016 оны				55.0		55,4

4 СӨЭМТ-д хамтарсан хяналт үнэлгээ хийх үед авсан сэтгэл ханамжийн судалгааны дүнгээр тодорхойлсон.

5 Сургуулийн насны хүүхдүүдийн дунд хийсэн Амны хөндийн эрүүл мэндийн дадал хандлагыг үнэлэх судалгааны дүн.

6 Тайлбар 5- тай адил

байдлаар						
----------	--	--	--	--	--	--

4) Нөлөөлөл, үр нөлөө:

Өнгөрсөн онд аймгийн удирдлага, сумдын ЗД болон ЭМТ-ийн дарга нарыг хамруулсан тайлангийн хурлыг зохион байгуулсны үр дүнд нийт сумдын орон нутгийн хөгжлийн сангийн төсвөөс эрүүл мэндийн салбарт зарцуулсан төсвийн эзлэх хувь 0,4 р нэмэгдсэн

-Сумын ЭМТ-үүдэд хяналт үнэлгээ хийх үедээ сумын Эрүүл мэндийн салбар зөвлөлийн⁷ үйл ажиллагаатай танилцаж, арга зүй, дэмжлэгээр хангаж ажилласны үр дүнд сумын түвшинд эрүүл мэндийн үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо нэмэгдэж байна.

-ЭМГ, БСГ-ын мэргэжилтнүүд хяналт үнэлгээний талаар хамтарсан уулзалт зохион байгуулж, хамтарсан хяналт үнэлгээ хийсэн нь тус 2 байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлсэн.

-ЭМГ, БСГ, зарим сумдын эмч мэргэжилтнүүд холбогдох сургалтын хөтөлбөр төлөвлөгөөгөө өөрсдөө боловсруулан тайлагнаж, бүх үйл ажиллагаанд хамтран оролцдог болсон.

- Ховд аймагт зохион байгуулсан бүсийн зөвлөлдөх уулзалтанд ЭМГ болон орон нутгийн оролцоо нэмэгдэж нийт санхүүжилтийн 30% ийг хариуцан зохион байгуулсан байна.

-Ховд аймгийн хэмжээнд бүх сургууль, цэцэрлэгүүд хүүхдүүдийн дунд амны хөндийн үзлэгийг жилд 2 удаа хийж, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

-Эрүүл мэндийг дэмжигч сургууль, цэцэрлэг шалгаруулах 2 сарын аяны хүрээнд 1801 хүүхдийг эмчлэн эрүүлжүүлсэн ба⁸ Ховд аймагт 6 сургууль эрүүл мэндийн кабинет шинээр бий болгож, 9 сургууль кабинетээ тохижуулж, 15 сургуульд эрүүл шүдтэй ангиуд бий болж,

-Загвар эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааг суртчилан, туршлагыг нь түгээн дэлгэрүүлснээр шинээр загвар үйлчилгээтэй ЭМТ болох сонирхол нэмэгдсэн. Тухайлбал Ховд аймгийн Мөнххайрхан, Дуут сум, ГА аймгийн Жаргалан сумын ЭМТ сувилахуйн загвар Говь-Алтайн Чандмана сум НЭМ- ийн загвар төв болохоор зорилт тавин ажиллаж байна.

а) Үр нөлөөний түвшинд олон хувь нэмэр оруулагчид байдаг ба төсөл түүний зөвхөн нэг нь юм. Яагаад төсөл хувь нэмэр оруулагчдын нэг нь хэмээн тооцогдож буйг үнэлэнэ үү.

- Төслийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орон нутгийн удирдлагуудын төлөөлөл ордгоороо төслийн тогтвортой байдлыг хангахад чухал нөлөөтэй байна.
- Орон нутгийн болон үндэсний түвшний байгууллагуудын хамтын ажиллагаанд дэвшил гарахад төсөл гол үүрэг гүйцэтгэв.
- Эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн чадавхи бэхэжсэн.
- Эрүүл мэндийн үйл ажиллагаанд бусад салбар, байгууллагуудын оролцоог нэмэгдүүлсэн.
- Орон нутгийн төсвөөс эрүүл мэндийн үйл ажиллагаанд зориулж тусгайлсан төсөв баталдаг болсон ба энэ санхүүжилт жилээс жилд тогтвортой нэмэгдэж байна.
- Төслийн ухуулга нөлөөллийн ажлын үр дүнд ЭМ-ийн байгууллагууд НЭМ- ийн үйл ажиллагаанд төсөвлөгдсөн хөрөнгийг зориулалтын дагуу бүрэн зарцуулдаг болсон.

7 Сумын Эрүүл мэндийн салбар зөвлөл гэдэг нь сумын ЗД-н удирдлага дор ажилладаг, эрүүл мэндийн талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагааг зохицуулах, салбар хоорондын хамтын ажиллагааг хангах үүрэгтэй зөвлөл юм.

8Аяны тайлан

5) Төслийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд нөлөөлсөн ямар нэгэн онцгой нөхцөл (эерэг ба сөрөг байдлаар) байсан уу? Дотоод нөхцөл байдал

1. Эерэг:

- Төслийн жилийн төлөвлөгөө, төсвийн төлөвлөлт хэрэгжихүйц, бодитой, төслийн шалгуур үзүүлэлтэд чиглэж нарийвчлан хийгдэж чадсан.
- Санхүүгийн тогтвортой байдал.
- Байгууллагын удирдлага болон бусад нэгжийн дэмжлэг хамтын ажиллагаа сайн байв.

2. Сөрөг:

-Төслийн хүрээнд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран олон нийтийн мэдлэг, дадал, хандлагыг үнэлэх судалгааг хийсэн боловч хугацаа нилээд сунжирсан нь нэгдүгээрт төслийн багийн судалгааны ажлын талаарх мэдлэг, туршлага дутмагаас хоёрдугаарт тухайн судалгааны хамрах хүрээ хэт өргөн байсан хэдий ч шаардлагатай төсвийг буруу тооцоолсон зэргээс шалтгаалж төлөвлөсөн хугацаанд судалгааг дуусгаж чадаагүй.

б) Гадаад хүчин зүйл:

1. Эерэг:

- Төслийн орон нутгийн зарим ажилтнуудын гэрээ дуусаж 6-11 сарын хүртэлх хугацаанд Ховд, Говь-Алтай аймгуудад тусгайлсан төслийн ажилтан ажиллаагүй ч төслийн үйл ажиллагаа жилийн төлөвлөгөөний дагуу амжилттай бүрэн хийгдсэн нь хамтрагчдын өөриймсөг байдал, чадавхи бий болсныг харуулж байна.
- Үндэсний түвшний хамтрагчдын дэмжлэг, хамтын ажиллагаа сайн, ямар нэгэн бэрхшээл учирч байсангүй.
- Боловсролын байгууллага хүүхдийн эрүүл мэнд рүү чиглэсэн үйл ажиллагаанд анхаарлаа хандуулж, эцэг эх олон нийтийг татан оролцуулдаг болсон.

2. Сөрөг:

- УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн дараа гол хамтрагч болох АЭМГ, АБСУГ-ын дарга нарыг сонгох явц удааширсантай холбоотой төслийн тайлангийн хурал болон жилийн зөвлөлдөх уулзалтын хугацааг товолж бэлтгэл хангах ажилд маш их бэрхшээл тохиолдсон.
- Удирдах, шийдвэр гаргах түвшний удирдлагуудын 80 гаруй хувь нь өөрчлөгдсөнтэй холбоотойгоор оны сүүлийн хагас жилд төслийн талаар ухуулга нөлөөллийн үйл ажиллагааг дахин хийхэд нилээд цаг хугацаа зарцууллаа.
- СӨЭМТ-үүдийн НЭМ-ийн ажилтнуудын дийлэнх нь шинэчлэгдэж сургалтад хамрагдаагүй мэргэжилтнүүд томилогдох болсонтой холбоотой олон нийтийн сургалт сурталчилгааны тасралтгүй байдал, чанарт сөрөг нөлөө үзүүлж байв.
- 2016 онд төслийн гол зорилтот бүлэг болсон АЭМГ-ын дарга, зарим мэргэжилтнүүд шинэчлэгдсэн тул тэднийг дахин сургах хэрэгцээ шаардлага гарч байна.
- БӨ аймгийн БСУГ-ын шинэ дарга нь АЭМГ-тай хамтран ажиллах тал дээр анхаарахгүй байгаа нь хамтын ажиллагаанд ахиц гарахад сөргөөр нөлөөлж, төлөвлөсөн 2 үйл ажиллагаа хийгдсэнгүй.

6. Төсөл дуусах шатанд бэлдэхэд болон төслийн гэрээт хугацаа дууссаны дараа тогтвортой байдлыг хангах тал дээр төслийн зүгээс ямар арга хэмжээ авсан бэ?

а. Төслийн үйл ажиллагаа хэрэгжиж дууссаны дараа ямар үйл ажиллагааг хэн хариуцаж цаашид үргэлжлүүлэх вэ ?

Үйл ажиллагаа	Хэн хариуцах
2016 оны 12 сард төслийн зорилтот аймгуудад тус бүрд нь /45-50 оролцогч/ Төслийн жилийн зөвлөлдөх уулзалт, Эрүүл мэндийн удирдлага мэргэжилтнүүдийн жилийн тайлангийн хурал/60-70 оролцогч/ зэрэг 2 томоохон уулзалтыг зохион байгууллаа. Эдгээр уулзалтуудын гол зорилго нь төслийн үйл ажиллагаа үр дүнг цаашид тогтвортой үргэлжлүүлэхэд хамтрагчид хэрхэн оролцох вэ гэдгийг хамтдаа хэлэлцэн шийдэх явдал байсан бөгөөд шинээр томилогдсон удирдлагууд төслийн тогтвортой байдлыг хангахад арга зүйн болон хөрөнгийн хэрэгцээтэй дэмжлэг туслалцааг үзүүлж үр дүнтэй хамтран ажиллахад санал нэгдсэн нь чухал ач холбогдолтой байв.	
ЭМГ-ын мэргэжилтнүүд болон анхан шатанд ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байранд нь тасралтгүй сургалт, шавилан сургалт явуулах, чадавхижуулах	ЭМЯ, ЭМХҮТ, Аймгийн ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, БОЭТ. Аймгууд мэргэжилтнүүдийн мэдлэг ур чадварыг үнэлэх, сургалтын хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх зэрэгт суралцсан, аргачлалтай болсон, хүний нөөцийн чадавхи бий болсон учраас тасралтгүй үргэлжлүүлэх боломжтой.
Загвар эрүүл мэндийн төв, Загвар сургууль Загвар цэцэрлэгийн туршлага түгээх	Аймгийн ЭМГ, БСГ, ЭМТ, Сургууль, цэцэрлэгийн дарга нарт санаачлага, сонирхол бий болсон туршлагажсан
Бүсийн зөвлөлдөх уулзалтууд, Туршлага хуваалцах	Аймгийн ЗДТГ-ын НХХ, Удирдах зөвлөлийн гишүүд, ЭМГ, БСГ- ууд чадваржсан, ач холбогдлыг ойлгосон.
Хяналт үнэлгээг тасралтгүй, удирдамжийн дагуу, зөвлөн туслах зарчмаар гүйцэтгэх	АЭМГ мэргэжилтнүүд хяналт үнэлгээ хийх ур чадварт суралцсан
Зөвлөн туслах багийг газар дээр нь ажиллуулах	
СӨЭМТ-дийн чанарын багийн үйл ажиллагаа	СӨЭМТ-ийн мэргэжилтнүүд чадваржсан, ЭМГ- аас тавих хяналт сайжирсан.
Эмнэлгийн мэргэжилтний зайн сургалтыг тасралтгүй зохион байгуулах	ЭМГ- ын хүний нөөцийн мэргэжилтнүүд, сум өрхийн ЭМТ- ийн эрхлэгч нар чадваржсан
Эрүүл мэндийн дэмжигч Загвар гудамж	Аймгуудад Загвар гудамжууд бий болсон. Аймаг, Сумын ЗДТГ- ууд туршлагажсан.
Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа	ЭМСЯ, БСШУЯ- ны болон аймгуудын Засаг дарга нарын төрийн хөтөлбөрт тусгагдсан
Олон нийтэд чиглэсэн эрүүл мэндийн мэдээлэл сурталчилгаа, кампанит ажлууд	Мөн орон нутгийн хамтрагч байгууллагуудад хүний нөөцийн болон санхүүгийн чадавхи бий болсон. -Цэцэрлэгүүд багш нарынхаа ажил үүргийн хуваар болон ажил дүгнэх гэрээнд хүүхдэд шүд угаах, гар угаах бусад дадлыг эзэмшүүлэх, эрүүл мэндийг хянах эрүүлжүүлэх ажлыг тусгасан тул цаашид тогтвортой үргэлжлэх болно. -Аймгийн ЗД мөрийн хөтөлбөрт “Амны хөндийн эрүүл мэнд”-ийн талаар тодорхой ажлуудыг хэрэгжүүлэхээр тусгагдсан тул АЭМГ, АБСУГ хариуцан амны хөндийн эрүүл мэнд аян үргэлжлэх болно.

6. Төслийн хөгжлийн зорилго, урт хугацааны үр дүнг бэхжүүлэхийн тулд төсөл хэрхэн ажиглаж байна вэ? (удирлага, мэдлэг/ур чадвар, санхүү талаас)

• **Удирдлагын тогтвортой байдал**

- ЭМСЯ, БСШУЯ, ЭМХҮТ, НЭМҮХ зэрэг үндэсний хэмжээний байгууллагуудын мэргэжилтнүүдийг зарим үйл ажиллагаанд урьж оролцуулах, ухуулга нөлөөллийн үйл ажиллагаанууд зохион байгуулдаг.
- Сонгуулийн үр дүнд шинээр бий болсон удирдлагын багийн хөтөлбөр бодлоготой төслийн үйл ажиллагааг уялдуулах, тэднийг хөтөлбөрөө боловсруулахад төслийн зарим зорилгод чиглэсэн үйл ажиллагааг тусгуулах зэрэгт анхаарал хандуулж байна.
- Төслийн УЗ-ийн дарга, гишүүдийг үйл ажиллагаандаа оролцуулдаг.
- Хяналт үнэлгээгээр сумдад ажиллахдаа сумын ЗД болон удирдлагуудтай уулзаж, төслийн үйл ажиллагаа түүний үр дүнг танилцуулж, санал солилцож ажилласан.

• **Техникийн тогтвортой байдал**

- Төслийн төлөвлөгөөг боловсруулахад орон нутгийн болон салбарын яамдын хэрэгцээ, эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүдийг авч үзэж, холбогдох мэргэжилтний саналыг авч төлөвлөлтөд тусгаж хамтран ажиллав.
- Төслийн аливаа үйл ажиллагааг АЭМГ болон БСУГ-ын мэргэжилтэнд хариуцуулан хамтран зохион байгуулж, тэднийг чадваржуулсан.
- Төслөөс зохион байгуулсан сургалтуудад орон нутгийн сургагч багшийг авч ажиллуулан тэднийг чадваржуулсан.
- Үр дүнтэй өөрчлөлтүүдийг хэвээр хадгалахад хамтрагчид хэрхэн оролцох дэмжих талаар тэдэнд ухуулга нөлөөллийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах, сайн жишээг сурталчлах, урамшуулав.
- Төрийн байгууллага болон бусад ТББ-дтай аль болох үйл ажиллагаагаа давхцуулахгүй байхад анхаарсан.
- Сургалт үйл ажиллагааг аль болох аймгийн төвд танхимын хэлбэрээр хийхээс татгалзаж нэгж дээр зохион байгуулахад анхаарав. Ингэснээр тухайн нэгжийн мэргэжилтнүүд ажиллагсдын зохион байгуулах арга зүйн мэдлэг ур чадвар дээшилж харилцан биенээсээ суралцах боломж бүрдэж байна.

• **Санхүүгийн тогтвортой байдал**

- Сайн туршлагаудыг хуваалцах боломжоор хангаж, санхүүгийн болон арга зүйн дэмжлэг үзүүлээ.
- Төслийн аливаа үйл ажиллагаанд хамтрагчдаас тодорхой хэмжээний санхүүгийн дэмжлэг авч ажилласан. Тухайлбал сургалтын өрөөний түрээс, оролцогчдын томилот хуваалцах /5 өрдийн сургалтын 2 өрдийн томилотыг тухайн байгууллага хариуцах гэх мэт/
- Орон нутгийн чадварлаг мэргэжилтнүүдийг бусдадаа мэдлэг туршлагаа хуваалцах боломжийг бүрдүүлэн дэмжлэг үзүүлэхэд анхаарч ажилласнаар тэднийг чадваржуулсан төдийгүй төвийн мэргэжилтэнд өндөр зардал гаргахгүй байх сайн жишээ болсон.

7.Төслийн үр дүнг үндэсний болон орон нутгийн бодлого, төлөвлөгөө, тэргүүлэх чиглэлтэй уялдуулж холбохын тулд юу хийсэн бэ?

- Амны хөндийн эрүүл мэнд, хүүхдийн эрүүл мэнд, хүүхдийн осол гэмтлээс сэргийлэх, Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлж антибиотикийн хэрэглээг бууруулах зэрэг олон нийтийн мэдлэгийг дээшлүүлж зөв хандлага бий болгох үйл ажиллагаануудыг үндэсний бодлого хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүллээ.

- Сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан орон нутгийн шинэ удирдлагын багийн 5 жилийн хөтөлбөр болон 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Нийгмийн эрүүл мэндийн зорилтууд бүрэн тусгагдсан бөгөөд 2017 онд хамтран ажиллах чиглэл тодорхой болсон байна.
- Зорилтот аймаг бүрт “Төслийн тогтвортой байдлыг хангахад хамтрагчдын дэмжлэг оролцоо” сэдэвт жилийн зөвлөлдөх уулзалт болон Эрүүл мэндийн байгууллагуудын жилийн тайлангийн хурлыг зохион байгуулж нийт 329 салбар салбарын төлөөлөл оролцож хамтран ажиллах зөвлөмж төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна. Уг уулзалтуудад төслийн талаар мэдээлэл хийсэн ба төслийн үр дүнд бий болсон үр дүн өөрчлөлтүүд, шилдэг туршлагауд, төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх арга замуудын талаар хэлэлцүүлэг зохион байгуулж нэгдсэн ойлголтод хүрсэн. Мөн Говь-Алтай Баян-Өлгий аймгуудын дээрх уулзалтуудад Эрүүл мэндийн яамны холбогдох мэргэжилтнүүд оролцон үндэсний хэмжээнд хэрхэн хамтран ажиллах тухайд санал нэгдэв.
- ЗДТГ-ын НХХ-ийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, ЭМГ-ын удирдлага, мэргэжилтнүүдтэй байнгын хамтран ажилласны үр дүнд АЗД-ийн 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт төслийн эхлүүлсэн үйл ажиллагааг үргэлжлүүлэх боломжтой олон хөтөлбөр, үйл ажиллагаа тусгагдсан.

8.Хөгжлийн явц процесст иргэний нийгэм²-ийн үүргийг бэхжүүлэхийн тулд юу хийсэн вэ?

a. Хэрэгжүүлэгч байгууллагынхаа хувьд төсөл өөрөө хэрхэн бэхжсэн бэ?

- Төслийн багийн гишүүд чадваржсан, туршлагажсан. Орон нутгийн ажилтнууд АЭМГ-т мөн мэргэжилтнээр хавсран ажиллаж байна.
- Төсөл Олон улсын байгууллагуудтай⁹ үр дүнтэй түншлэж ажиллав.
- Батлагдсан төсвийн хүрээнд төлөвлөсөн үйл ажиллагааг зарим олон нийтийн бүлэгүүд¹⁰ийн оролцоотойгоор амжилттай хэрэгжүүлсэн .

b. Тогтвортой өөрчлөлтийг бий болгох иргэний нийгмийн байгууллагуудын чадавх хэрхэн сайжирсан бэ?

- БӨ, ГА аймгуудад төрийн бус байгууллагуудын уулзалтыг зохион байгуулсан нь харилцан мэдээллээ солилцож, цаашид хамтран ажиллах эхлэл тавигдсан хэдий ч тогтвортой үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллага цөөн бөгөөд 2016 онд төслийн үйл ажиллагаанд тэдний оролцоо хангалттай бус байв.
- Боловсролын байгууллагуудтай хамтран ажиллах ажлын хүрээнд эрүүл мэндийг дэмжигч клубын хүүхдүүдийн дунд жижиг төсөл бичих уралдаан зарлан санхүүжүүлснээр тэдний чадвар, идэвх санаачилга, үе тэнгийнхэндээ нөлөөлөх нөлөөлөл нэмэгдсэн байна.
- Өрхийн ЭМТ-тэй хамтран ажилладаг сайн санааны туслагч нарт сургалт хийж, тэднээр сургалтын төсөл бичүүлэн идэвхжүүлэн ажилласан.

Төслийн зүгээс хүний эрхийг дээдлэх эсвэл ялгаварлан гадуурхах байдлын эсрэг юу хийсэн бэ?Энэ ажлын тань үр дүн ямар байдлаар харагдаж байна вэ?

- Төслийн бүхий л үйл ажиллагааг хүний эрхийг дээдэлсэн, ялгаварлан гадуурхах байдлын эсрэг, олон нийтийн эрх тэгш оролцоог дэмжсэн зарчмаар зохион байгуулсан.
- ЭМГ, БСГ-ын мэргэжилтнүүдийн сумын ЭМТ, сургууль, цэцэрлэгүүдэд хяналт үнэлгээг хийхдээ хянах шалгах, буруутай эзнийг олох, хариуцлага тооцох, ажлаас халах зэрэг уламжлалт арга барилыг нь өөрчлөн нөхөрсгөөр зөвлөн туслах, ажил

9 Дэлхийн зөн Монгол ОУБ, НҮБ- ийн ХАС, Каритас Чех, Талын нүүдэлчдийн эх булаг гэх мэт.

10 Загвар гудамж- удирдах зөвлөл, Хүүхдийн эрүүл мэндийн клуб гэх мэт

сайжруулах зарчмаар ажиллах арга зүйд сургаснаар анхан шатны нэгж байгууллагын удирдлага болон ажиллагсад ажлаа үнэлүүлэх, дээд шатны байгууллагын зөвлөгөө, дэмжлэгийг авах санал санаачилга гаргах болон дээд байгууллагаа үнэлэх үнэлэмж, сэтгэл ханамж дээшилж байна.

- Анхан шатанд ажиллаж буй залуу мэргэжилтнүүдийг ажлын байран дахь болон шавилан сургалтад хамруулснаар тэдэнд зөвхөн мэдлэг чадвар эзэмшүүлээд зогсохгүй харилцааны соёлд суралцан бусадтай илүү дотно танилцах санал бодлоо нээлттэй хуваалцах боломжийг бий болгодог.

c. Төсөл нь хүйсийн тэгш байдал, эмэгтэйчүүдийг чадавхжуулах талаар тусгайлан оруулсан эсэх?

- Төслийн бодлогын баримт бичгийн 7.4.3, 7.5.2, 7.6.2, 11.4 зэрэг бүлэгүүдэд хүйсийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг чадвахижуулах талаар тусгайлан оруулсаны дагуу төслийн бүхий л үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж байна.

d. Хүйсийн тэнцвэртэй байдал бий болгох болон эмэгтэйчүүдийг ямар байдлаар чадавхжуулсан бэ?

- Үндэсний болон орон нутгийн хамтрагчдын дийлэнх нь эмэгтэйчүүд учраас төслийн бүхий л үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн эзлэх хувь байнга өндөр байдаг. Төслийн зүгээс эмэгтэйчүүдийг сургалт сурталчилгаанд хамруулах замаар чадваржуулсан бөгөөд ялангуяа Сум өрхийн эрүүл мэндийн төв, сургууль цэцэрлэгүүдэд ажиллагчдын 80 гаруй хувь нь эмэгтэйчүүд ажилладаг ба өнгөрсөн онд төслийн үйл ажиллагаанд оролцогчдын 68 хувь нь эмэгтэйчүүд байна. Мөн олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгаа, уралдаан тэмцээн болон олон нийтийн мэдлэг дадал хандлагын байдлыг үнэлэх судалгаанд хамрагдагсдын 74 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байна.
- Монгол улсад эрүүл мэндийн болон нийгмийн аливаа үйл ажиллагаанд эрэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй, мөн эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдийнхээс 4-5 насаар бага, мөн эрэгтэйчүүдийн дунд зүрх судас, чихрийн шижин, осол гэмтэл, хоол боловсруулах замын эмгэгүүд эмэгтэйчүүдийнхээс илүүтэй байдаг. Иймд төслийн зүгээс мөн эрэгтэйчүүдийг төслийн үйл ажиллагаанд татан оролцуулах, тэдний мэдлэг хандлагыг өөрчлөхөд тусгайлан анхаарч ажилладаг.

Сайн төсөл/ санхүүгийн менежментийг дэмжихэд төсөл хэрхэн яаж ажилласан бэ?

- Төсөл болон захиргаа санхүүгийн багийн хамтын ажиллагаа илүү сайжирсан жишээ нь төсөв болон тайлан үргэлж цаг хугацаандаа байдаг.
- Дотоодын сургалтын үеэр НТБ-н санхүүгийн бодлогын талаар шинэ мэдээлэл авсан.
- Төслийн бүх ажилтнууд байгууллагын захиргаатай эд хөрөнгийн хариуцлагын гэрээг жил бүр шинэчлэн байгуулдаг.
- Төслийн гэрээ дуусгавар болсон ажилтнууд эд хөрөнгийн бүртгэлийн дагуу гарын үсэг зурж хөрөнгөө хүлээлцсэн. Төсөл болон суурин төлөөлөгчийн шийдвэрээр томилогдсон багийн хамтарсан эд хөрөнгө бүртгэл тооллогыг жилд 2 удаа хийж хянадаг.
- Жилийн төлөвлөгөөний дагуу төсөл загвар төвүүдээс жижиг төслийн саналуудыг хүлээн авдаг. Аливаа захиалга, хэрэгцээт тоног төхөөрөмж нь байгууллагын худалдан авалтын шалгуур зарчмын дагуу явагддаг. Сургалт сурталчилгааны материал хэвлүүлэхэд ч түүнийг дагаж мөрддөг.

а) Өмнөх жилийн аудитын зөвлөмжийн дагуу 2016 онд ямар арга хэмжээ авч ажилласан бэ?

- Улаанбаатар аудитын компанийн 2015 онд төслийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын үнэлгээний зөвлөмжийг мөрдөж ажиллалаа.
- Тус аудитын компаниас манай төслийн санхүүгийн үйл ажиллагаанд онцгойлон анхааруулах зөрчил доголдол илрээгүй, мөн өмнөх жилүүдэд аудитын байгууллагаас өгөгдсөн зөвлөмжүүдийн хэрэгжилт хангалттай байна гэж үзсэн учир тусгайлсан зөвлөмж захидал /менежемент letter/ өгөх шаардлагагүй гэсэн хариу ирүүлсэн.

ЭМАШТҮБ-2 төслийн тухайд байгууллагын хэмжээнд өгөгдсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Зөвлөмж	Хэрэгжилт
Ажилчдад олгож буй эрүүл мэндийн үзлэг оношилгооны дэмжлэгээс татварын хуулийн дагуу татварыг тооцож төлөх	Санхүүгийн алба энэ зөвлөмжийг ажилтнуудад танилцуулан хэрэгжүүлж ажиллаж байна.
Үнэлээчийн цалин хөлсийг 2 сард хувааж өгсөн тохиолдолд татвар, даатгалыг мөн 2 удаа суутган авах, хэрвээ тухайн сардаа багтаан 2 хувааж өгсөн тохиолдолд нэг удаа суутган тооцох	Цаашид өндөр цалинтай ажилтан хөлсөлж цалинг хуваан олгох тохиолдол бүрт энэ зөвлөмжийг анхаарч хэрэгжүүлэх болно.
Санхүүгийн зардал бүрт дэмжих баримтуудыг байгууллагын санхүүгийн бодлого дүрэмд заасны дагуу иж бүрэн бүрдүүлэх	Төслийн ажилтнуудын дотоод сургалтад санхүүгийн захирал оролцон зөвлөмжийг танилцуулсан, хэрэгжилтэд орон нутгийн ажилтнууд анхаарч, төслийн удирдлагын зүгээс хяналт тавьж ажиллаж байна.
Үйл ажиллагаа бүрийн тайланд нотолгоо болохуйц баримтуудыг /фото зураг гэх мэт/ заавал хавсаргаж баримтжуулж хэвших.	Тайлангуудад 1-2 зураг хавсаргаж хэвшиж байна.
Төслийн хүрээнд хамтрагч байгууллагуудад эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авч хангалт хийсэн тохиолдолд NLM байгууллагын хөрөнгөд бүртгэхгүй. Тухайн хөрөнгийн хүлээн авсан хэрэглэгч байгууллага хүлээн авч хөрөнгөдөө бүртгэсэн баримтыг хавсаргаж байх	Төслийн зүгээс зарлагдсан уралдаанд хамгийн сайнаар шалгарсан жижиг төсөлд тоног төхөөрөмж худалдан авдаг. Ингэхдээ НЛМ-М санхүүгийн журамд заасны дагуу банкны шилжүүлэг хийдэг. Төслийн ажилтны зүгээс зааварчилгаа өгсний дагуу жижиг төслийн ялагчид тоног төхөөрөмж худалдан авч шаардагдах санхүүгийн дэмжих баримтуудыг төсөлд өгдөг. Төсөл ихэнхдээ эмнэлгийн тоног төхөөрөмжийг худалдан авч хүргэлт хийгээд байдаггүй. Гэхдээ ямар тохиолдол вэ гэдгийг бид анхаарч үзнэ.

9. Энэ жилийн хамгийн чухал туршлага/сургамжаа дурдана уу

ЭМГ, БСГ- уудын мэргэжилтнүүдийн хамтарсан хяналт үнэлгээний өргөтгөсөн хурлаас гарсан саналын дагуу Ховд аймгийн Ховд суманд зөвхөн “ Хүүхэд өсвөр үеийн эрүүл мэндийг үнэлэх нь” сэдэвтэй удирдамж гарган 2 байгууллага ЭМТ, сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаанд үнэлгээ хийсэн нь харилцан бие биенээсээ суралцаж нэгдсэн үнэлгээ хийхэд ихээхэн ач холбогдолтой үйл ажиллагаа болов.

- Баян-Өлгий аймагт энэ оны эхэнд хүүхдийн өвчлөл эндэгдлийг бууруулах аймгийн зөвлөгөөнийг зохион байгуулсны дүнд аймгийн бүх байгууллагын удирдлагууд хүүхдийн эрүүл мэндийн асуудалд илүүтэй анхаардаг болсон.
- Чанар сайжруулах сургалтын дадлагын хэсгийг сумын ЭМТ-д очиж хийж, оролцогчид сургалтын эхний өдрүүдэд боловсруулсан шалгах хуудсаа ашиглан явуулсан нь үр дүнтэй аргачлал болж, сургалтын дараа олон өөрчлөлтүүд гарсан.
- Эрүүл мэндийг дэмжигч сургууль, цэцэрлэг шалгаруулах 2 сарын аян зарлаж шалгаруулснаар сургууль, цэцэрлэгүүдэд хүүхдийн эрүүл мэндийн талаар маш олон ажлууд хийгдэж, удирдлагын дэмжлэг, орчин нөхцөл сайжирч, багш, эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлж чадсан. Энэ уралдааны хүрээнд эрүүл шүдтэй анги хамт олон, эрүүл мэдийн кабинет шалгаруулснаар эрүүл шүдтэй хүүхдийн хувь нэмэгдэж эрүүл дадал хэвшилд суралцах дэмжлэгт орчин сайжирсан.
- Төслийн жилийн зөвлөлдөх уулзалтыг аймаг бүрт орон нутагт нь хийсэн нь олон талын оролцоог хангаж чадсанаараа үр дүнтэй ажил болсон.
- Аймгуудын ЭМГ-тай хамтран СӨЭМТ-ийн тайлангийн хурлыг орон нутгийн удирдлагуудыг хамруулан зохион байгуулснаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд орон нутгийн удирдлагын дэмжлэгийг нэмэгдүүлэх томоохон ухуулга нөлөөллийн ажил болж чадлаа.
- АЭМГ-ийн мэргэжилтнүүдийн бие биенээ орлон гүйцэтгэх, багаар хамтран ажиллах, хяналт үнэлгээ хийх ур чадвар жигд дээшилсэн, хяналт үнэлгээг анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд өөрсдөө хүсч захиалж хийлгэдэг болсон.
- СӨЭМТ-д дотооддоо хяналт үнэлгээ хийх шалгах хуудсыг хэрэглэж эхэлсэн.
- Төслийн баг орон нутагт илүү олон ажилласнаар төслийн үр дүн өөрчлөлт, орон нутгийн хэрэгцээг илүү бодитой олж харсан нь дараа жилийн төлөвлөлтөд үр дүнтэй байв.

Сургалж:

- ЭМГ-ын мэргэжилтнүүд тогтвортой ажиллахгүй, байнга өөрчлөгдөж, шинэчлэгдэж байгаа тул тэднийг дахин сургах хэрэгцээ байнга гарч байна.
- Сонгуулийн сурталчилгаа болон албан тушаалтнуудын шинээр томилгодох хугацааг ажил төлөвлөхдөө буруу тооцоолсноос зарим үйл ажиллагаа хойшлогдож, зарим нь тасрахад хүрсэн.
- ХӨЦМ-ийн сургалтууд олон удаа хийсэн ч тандалт хийгдээгүй учраас үр дүн өөрчлөлт жигд сайн биш байна.
- Загвар байгууллагуудын хөгжүүлэх гол хөшүүрэг болох тасралтгүй үнэлгээ хийгдээгүй.
- Сургуулийн захиралууд ихээхэн өөрчлөгдсөнөөс Шүдний хуурай угаалга¹¹ зарим сургуулиудад зогсонги байдалд орсон.
- Судалгааны ажил төлөвлөсөн хугацаандаа дуусаагүй. Учир нь хамрах хүрээг хэт өргөн сонгосон мөн санхүүжилтийг хамтрагчидтай хуваалцахаар төлөвлөсөн хэдий ч тэдний төсөв танагдсантай холбоотой судалгааны ажилд зардал хуваалцаагүй.

10) Төсөл нь бусад ТББ-ууд, байгууллагууд, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хэрхэн хамтарч ажилласан бэ? Туршлага судлах аялалд оролцсон эсэх?

¹¹ Оогүйгээр шүд угаадаг аргыг Хуурай угаалга гэж нэрлэдэг. Сургуулийн 1-5-р ангийн сурагчид ангиадаа үдийн цай уудаг бөгөөд үүний дараа хуурай угаалгын аргыг төслөөс санаачлан хэвшүүлсэн.

- Төслөөс зохион байгуулсан бүсийн уулзалт, сургалтын нээлт болон дүгнэлтийн үйл ажиллагаанд орон нутгийн удирдлагуудыг оролцуулж, тэдэнд зорилго үйл ажиллагаагаа танилцуулахын зэрэгцээ, тэдний санал бодлыг сонсдог.
 - Аймгуудад үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын уулзалтыг зохион байгуулж, харилцан мэдээлэл солилцсон.
 - Сумдад хяналт үнэлгээ хийх, зөвлөн туслах багаар ажилласан баг бүр сумын ЗД, ЗДТГ-ын мэргэжилтнүүдтэй уулзаж, Эрүүл мэндийн салбар зөвлөлийн үйл ажиллагаатай танилцан, зөвлөмж өгч ажиллав.
 - Ховд аймгийн Чандмань сумын ЗД болон ЭМТ-тэй хамтран 3 аймгийн “Сувилахуйн загвар” ЭМТ-ийн сувилагч нарт зориулсан сургалт, туршлага судлах үйл ажиллагааг зохион байгуулсан.
 - Мөн Ховд аймагт “Өсвөр үеийн эрүүл мэндийн бүсийн зөвлөлдөх уулзалт “ –ыг БСГ зохион байгуулж 3 аймгийн БСГ, эрүүл мэндийн багш, хүүхдүүдийн төлөөлөл болон төслийн ажилтнууд оролцон хүүхдийн эрүүл мэндийн төлөө хийж буй шилдэг туршлагуудтай танилцав.
 - Ховд, Баян-Өлгий аймгийн төслийн 2 ажилтан Вьетнам улсад MDF- ийн сургалтанд оролцож Үр дүнтэй түншлэл хамтын ажиллагааг хэрхэн бий болгох талаар суралцан Жилийн зөвлөлдөх уулзалт, тайлангийн хуралд оролцогчид болон болон төслийн багийн хамт олон нийт 330 гаруй хүнд сургалт хийв.
- Жилийн турш төслийн үйл ажиллагаа хэрхэн хянагдсан**
- Төслийн жилийн зөвлөлдөх уулзалтыг аймаг бүрт зохион байгуулж тухайн аймагт төслийн хүрээнд бий болсон өөрчлөлт, үр дүн сургамжийг тайлагнан, хэлэлцэж хамтран ажиллах зөвлөмж, тогтвортой байдлын төлөвлөгөө гаргав.
 - Төслийн жилийн үйл ажиллагаатай уялдсан хяналт үнэлгээний төлөвлөгөө боловсруулан мөрдөж ажилласан.
 - Төслийн үйл ажиллагааны биелэлтийг “Үйл ажиллагаа, хяналтын төлөвлөгөө”-ний /Activity monitoring plan/ дагуу хянаж, жилийн эцсээр дүгнэж ажилласан.
 - Ховд аймгийн төслийн УЗ-ийн хурлаар 2016 онд хийсэн ажлын үр дүнг хэлэлцүүлсэн.
 - Төслийн удирдагч болон УБ төслийн ажилтан 3 аймгийн 5 суманд ажиллаж, төслийн сургалт, үйл ажиллагааны үр дүнтэй танилцаж, зорилтот бүлгүүдтэй уулзаж, ярилцан тэдний зарим хүсэлтийг төслийн зөвлөлтэй зөвшилцсөний дагуу шийдэж ажиллалаа.
 - Төслийн орон нутгийн ажилтнууд АЭМГ болон БСУГ-ын мэргэжилтнүүдтэй хамтран хяналт үнэлгээг 41 суманд хийж ажиллах үедээ төслийн сургалтын дараах үр дүнг үнэлж ажилласан.
 - Шалгуур үзүүлэлт бүрийн биелэлт, бодит өөрчлөлтийн түүх, эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийн статистик мэдээлэл зэргийг хагас бүтэн жилээр нэгтгэн гаргаж, дүгнэлт хийн ажиллаж байна.

2016 оны Үнэлгээ:

- **Үнэлгээний төрөл юу байв? (гадаад, дотоод эсвэл гадаад ба дотоод холимог уу)**

2016 онд төсөл өөрийн бодлогын баримт бичгийн 4-р хавсралтад заасан хяналт үнэлгээний төлөвлөгөө, зарчмын дагуу төслийн үйл ажиллагааны хэрэгжилт, шалгуур үзүүлэлтийн биелэлт, төсөвийн зарцуулалт зэрэгт дотоод хяналт үнэлгээг хийж ажиллав.

б/ 2015 оны үнэлгээ: Төсөл нь энэ үнэлгээний мөрөөр ямар арга хэмжээ авсан бэ? Төслийг сайжруулах болон суралцахад энэхүү үнэлгээ нь

хэрхэн ямар байдлаар хувь нэмэр оруулсан бэ?

2015 онд төслийн дунд хугацааны үнэлгээ хийгдэж дараах дүгнэлт зөвлөмжийг өгсөн болно.

Дүгнэлт	
- ЭМАШТҮ-г дэмжих орон нутгийн байгууллагуудын хамтын ажиллагааны бүтэц бий болсон байна.	
- Бүх түвшинд ЭМЯ, БЯ болон орон нутгийн удирдлагын дэмжлэг авч чадсан.	
- Үйл ажиллагаа бүрийн дараа хяналт үнэлгээ хийж, үр дүнг тооцдог болсон байна	
- Төслийн аймгуудын хүн ам ихэнх нь өвдсөн үедээ СӨЭМТ-үүдэд очиж үйлчлүүлж байгаа нь АШТҮний чанар, хүртээмж дээшилсэнийг илтгэж байна.	
- Олон нийтийн СӨЭМТ-ийн үйл ажиллагаанд сэтгэл ханамж сайн байгаа нь АШЭМ тусламж үйлчилгээ хангалттай байна.	
- Эрүүл мэндийн үзүүлэлтүүдэд эерэг сайн өөрчлөлт гарсан.	
- Амны хөндийн эрүүл мэнд, гар угаах, эрүүл орчин бүрдүүлэх, эрүүл мэндийг дэмжигч загвар гудамж, эрүүл мэндийн загвар төвүүдийн үйл ажиллагаа зэрэг төслийн гол анхаарал хандуулсан үйл ажиллагаануудад харагдахуйц үр дүн өгсөн байна.	
- Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд шүд болон гар угаах дадлыг дэмжих орчин сайжирсан байна.	
- Иргэдийн түлэгдлийн талаарх мэдээлэл бага, эмийн зохистой хэрэглээ хангалтгүй байна. Мөн сурагчдын дунд хараа хамгааллын талаарх мэдлэг хангалтгүй.	
- Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай эрүүл мэндийн сүлжээ байгуулах зорилт хангалтгүй байна. Учир нь эдгээр байгууллагууд нь хувийн бие даасан байгууллагууд. Тиймээс энэ зорилт нь төслийн хэрэгжилтэнд хязгаарлагдмал байдлыг үүсгэж байна.	
- Тодорхой чиглэлээр бүсийн зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулдаг нь маш үр дүнтэй байна.	
- Эрүүл мэндийг дэмжигч загвар гудамжны үйл ажиллагаанд шат шатны ЗДТГ-ууд, багийн дарга нар идэвхтэй оролцож, урамшуулах, түгээн дэлгэрүүлэх зэрэг нааштай өөрчлөлтүүд гарсан байна.	
- Эрүүл мэндийг дэмжих хамт олон, үе тэнгийн сургагч багшийн сургалт, эрүүл мэндийн аян, уралдаан тэмцээн зохион байгуулсан нь илүү үр дүнтэй байна.	
Зөвлөмж	Авсан арга хэмжээ
Одоогийн хүрсэн түвшин, ололт амжилтыг тогтворжуулан төслийг үргэлжлүүлэх, улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлэх	2016 онд Боловсролын яамтай хамтран сургуулийн сурагчдын дунд эрүүл мэндийн олимпиадыг үндэсний хэмжээнд зохион байгуулав.
ЗДТГ, боловсрол, эрүүл мэндийн байгууллагын хамтын ажиллагаанд цаашид илүүтэй анхаарал хандуулах	2016 онд Аймаг бүрд жилийн зөвлөлдөх уулзалт, жилийн тайлангийн хурал зэрэг томоохон уулзалтуудыг хийж цаашдын хамтын ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна.
Түлэгдэл, осол гэмтлээс сэргийлэх мэдээллийг сурагчдад сонирхолтой арга хэлбэрээр, иргэдэд өрх, сумын эрүүл мэндийн төв, гар утас, интернет ашиглан хүргэх үйл ажиллагааг төслийн үлдсэн хугацаанд үргэлжлүүлэх	Түлэгдэлтээс сэргийлэх 3 цуврал гарын авалга бэлтгэн хэвлүүлж олон нийтэд түгээв. Өрхийн ЭМТ-үүд гар утасны сүлжээ ашиглан эрүүл мэндийн мессежийг өөрийн харьяа хүн амд хүргэж байна. Эмнэлгийн зарим

	<p>мэргэжилтнүүдийн Facebook группууд бий болж харилцан мэдээллээ солилцож байна.</p>
<p>Сургуулийн эмч нарын ажлын байрны тодорхойлолтыг сайжруулж эрүүл мэндийн тасралтгүй боловсрол олгох талаар тусгах.</p>	<p>Төслийн зорилтот аймгуудын хэмжээнд төслөөс хамтран боловсруулсан сургуулийн эмчийн ажлын байрны тодорхойлолтыг баталгаажуулан мөрдөж байна.</p>
<p>Загвар төвүүдийн үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх, туршлага солилцох арга хэмжээ, бүсийн уулзалтуудыг үргэлжлүүлэн зохион байгуулах</p>	<p>2016 онд: - Өсвөр үеийн эрүүл мэнд, гэрийн сувилахуй сэдэвт бүсийн үйл ажиллагаануудыг Ховд аймагт зохион байгууллаа.</p>
<p>Эмийн зохистой хэрэглээ, хүүхдийн хараа хамгаалал, хүүхдийн нас баралтыг бууруулахад тусгайлан төсөл хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэх.</p>	<p>Эмийн зохистой хэрэглээний талаар олон нийтэд зориулсан гарын авалга хэвлүүлэн түгээв. Олон нийтээс антибиотикийн хэрэглээний талаарх мэдлэг, дадал үнэлэх судалгааг авч дүнг жилийн зөвлөлдөх уулзалтын үеэр хэлэлцлээ. Судалгааны дүнг аймгууд өөрсдийн бодлого үйл ажиллагаанд тусган ажиллаж байна. Төслийн зорилтот аймгууд хүүхдийн эндэгдлийг бууруулах тусгай хөтөлбөрүүдийг боловсруулж байна.</p>

Тайланг бичсэн:

Төслийн удирдагч С.Баяржаргал